

## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

**“Эрдэнэс-Тавантолгой” ХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Сантехникийн засвар, үйлчилгээний сэлбэг хэрэгсэл” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭТТ/202001216дугаартай харьцуулалтын тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 11 цаг 10 минутад “Эрдэнэс-Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхрын хурлын өрөөнд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8,  
Финанс төв 5 давхар, 503тоот, Улаанбаатар-15160,  
Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн хэлтэс  
Утас: 75055555-506**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |      |  |
|---|------|--|
| <b>1.</b> Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2.</b> Тендер ирүүлэх, тендерийн нээлт               | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.   |
|   | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| <b>3.</b> Тендерийн иж бүрдэл                           | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| <b>4.</b> Тогтмол үнэ                                   | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5.</b> Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.  |
|   | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6.</b> Үнийн саналын хүчинтэй байх хугацаа           | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>30</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>7.</b> Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх            | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.   |
|   | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <i>ТШӨХ-д</i> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.  |
|   | 7.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.  |

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.


Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	<p>Үнийн саналыг жишиг маягтын дагуу ирүүлэх:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;</li> <li>2. Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг ижил төстэй бараа нийлүүлж байсан гэрээ, гэрээ дүгнэсэн акт эсхүл гэрээлэгч байгууллагын тодорхойлолт ирүүлэх;</li> <li>3. Санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сангаас тендерт оролцогчдын сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</li> <li>4. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар ирүүлэх/</li> <li>5. Нийлүүлэх барааны стандартыг тогтоосон баталгаажуулалтын гэрчилгээ эсхүл тусгай сертификат, бусад баримт бичгийн жагсаалтыг ирүүлэх;</li> <li>6. Техникийн тодорхойлолтыг хангаж байгаа эсэхийг үйлдвэрийн каталогоор нотолж ирүүлэх;</li> <li>7. Тендерт санал болгосон үнээр, санал болгосон хугацаанд техникийн тодорхойлолтын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн нийлүүлэхийг баталсан албан бичиг ирүүлэх;</li> </ol>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p><b>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</b> Тендерийг 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын <a href="http://www.tender.gov.mn">/www.tender.gov.mn/</a> цахим системд ирүүлэх</p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p><b>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</b> Нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 11 цаг 10 минутад “Эрдэнэс-Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхарт нээнэ.</p>
<b>ТӨӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>багцгүй</b></p>

**Дөрөв. Сантехникийн сэлбэг хэрэгслийн техникийн тодорхойлолт тоо хэмжээ**

№	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР / сэлбэг, барааны дугаар/	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЗУРАГ
1	Манометр, термометр	ш	8	Нам даралтын зуухны зориулалттай хосолмол сайн чанарын байх. Тус бүр 4 ширхэг	
2	Шилжүүлэг	ш	80	PVC ф15x20 20x25 25x32 25x15 32x15 сайн чанарын /Ginde-тэй дүйцэх /	
3	Дулаан ган хоолой	у/м	60	Ф15мм Ф20мм тус бүр 30м байх	
4	Цэвэр усны ган хоолой	у/м	50	Цайрдсан ган хоолой Ф32мм	
5	ус цэвэршүүлэх төхөөрөмжийн шүүлтүүр	ш	20	PP-маркийн 20инч хөвөн шүүлтүүр байх	
6	Троник	ш	20	Ф15x15мм PVC	
7	Троник	ш	20	Ф20x15x20мм PVC	
8	Троник	ш	20	Ф25x20x25мм PVC	
9	Троник	ш	20	Ф25x15x25мм PVC	
10	Нүхтэй худгийн хучилтын хавтан /бетон /	ш	5	Бохир усны худгийн нүхтэй хавтан Ф1000мм /Бетон/	
11	Люк, таг	ш	5	Бохир усны ширэм байх	

12	Сангийн лент	ш	100	Шар савтай, цагаан лент сайн чанартай	
13	Хаалт	ш	20	Ф25мм бөмбөлгөн ган хаалт сайн чанарын /Ginde-тэй дүйцэх/	
14	Хаалт	ш	20	Ф20мм бөмбөлгөн ган хаалт сайн чанарын /Ginde- тэй дүйцэх/	
15	Хаалт	ш	40	Ф15мм PVC дундын /Ginde-тэй дүйцэх/	
16	Хаалт Ф15мм ган	ш	10	Ф15мм бөмбөлгөн ган хаалт сайн чанарын /Ginde-тэй дүйцэх/	
17	Эр үзүүр	ш	40	Ф15мм PVC сайн чанарын /Ginde-тэй дүйцэх/	
18	Эм үзүүр	ш	40	Ф15*20мм PVC сайн чанарын /Ginde-тэй дүйцэх/	
19	Бохир усны булан	ш	10	Ф100мм шар өнгийн хуванцар, даацын	
20	Бохир усны хоолойн дулаалга	у/м	170	Ф150мм шар өнгийн шахмал хөөсөн дулаалга байх	
21	бохирын шилжүүлэг	ш	8	Ф100x100мм шар өнгийн хуванцар, даацын	

22	Бохир усны хоолой	у/м	150	Ф150мм шар өнгийн хуванцар, даацын	
23	бетонон кольца	ш	10	Бохир усны худагийн Ф1000мм	
24	Суултуурын таг	ш	60	350x435x155мм сайн чанрын хуванцар сууртуурын таг байх	
25	Угаалтуурын холигч	ш	40	П холигч нержин материалаар хийгдсэн.	
26	Босоо душны холигч	ш	20	Хана руу тогтоогчтой доошоо гаргалгаатай эл монтажийн нержин материалаар хийгдсэн.	
27	уян холбоос Ф15x15мм	ш	40	Ф15x15мм голчтой 60см урттай 10ата даралт даадага байх.	
28	Эр шээлтүүрийн дарагч хаалт	ш	20	Хана руу тогтоогчтой эл монтажийн нержин материалаар хийгдсэн.	
29	Муфта Ф-15мм, Ф20, Ф-25, Ф-32	ш	40	Ширмэн, ган байх Ф-15мм, Ф20, Ф-25, Ф-32 тус бүр 10ширхэг	
30	Шугамны дулаалга	у/м	80	Ф15мм Ф20мм 2м урттай хөөсан дулаалга тус түр 40м байх.	

31	Хаалт	ш	2	Ф150мм гагнадаг 16 ата даралтын бөмбөлгөн хаалт	
32	Агаар сорох жижиг сэнс	ш	8	220Вт ажилдаг 30х30см хэмжээтэй	
33	Изгон	ком	30	Ф15мм ган	
34	Гар тайл	ш	2	5тн даацтай гар ажиллагаатай сайн чанарын	
35	Изгон	ком	20	Ф25мм ган	
36	Цэвэр усны тоолуур	ш	6	Хүйтэн усны тоолуур Ф-15мм 25мм 32мм тус бүр 2ширхэг байх.	
37	Ахуй тосол	л	500	-30с <sup>0</sup> -аас -40с <sup>0</sup> температурт хөлдөхгүй байх.	
38	Цэвэр усны хуванцар хоолой	у/м	200	PVC Ф15мм Ф20мм тус бүр 100м байна. /Ginde-тэй дүйцэх/	
39	Зүлэг усалгааны насос	ш	2	Бүтээл 8-10м <sup>3</sup> /цаг Түрэлт 63м Чадал 3кВт Гаргалгаа Ф40мм	
40	Зүлэг усалгааны систем, бороожуулагч хошуу	Багц	1	Хавсралтаар-2	

### Захиалгын тайлбар:

Дээрх бараа материал нь цанхи хотхон болон уурхайн хэмжээнд сантехникийн шугам хоолой, сэлбэг хэрэгслэл нь 2020 оны бүтэн жилийн өдөр тутмын засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай, ашиглагдаг сэлбэг хэрэгслэл болно.



**Зүлэг усалгааны систем, бороожуулагч хошууны техникийн  
тодорхойлолт тоо хэмжээ**

д/д	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Техникийн тодорхойлолт	Зураг
1	Усалгааны насос	ш	1	4,5-аас 5,5кВт хүчин чадалтай 16бата даралт бүхий өргөлтийн босоо насос байх.	
2	Бороожуулагч хошуу	ш	200	Цохилтот бороожуулагч төмөр хошуу байх. Ф20мм	
3	Усжуулах хоолой Ф50мм	м	50	Ф50мм ханын зузан 3,3мм бра	
4	Усжуулах хоолой Ф40мм	м	50	Ф40мм ханын зузан 2,8мм бра	
5	Усжуулах хоолой Ф32мм	м	280	Ф32мм ханын зузан 2,2мм бра	
6	Усжуулах хоолой Ф25мм	м	250	Ф25мм ханын зузан 1,8мм бра	
7	Усжуулах хоолой Ф16мм	м	300	Ф16мм ханын зузан 1,4мм бра	
8	Хаалт	ш	2	Ф50мм хаалт PE	
9	Хаалт	ш	2	Ф40мм хаалт PE	
10	Хаалт	ш	5	Ф30мм хаалт PE	
11	Хог шүүгч	ш	2	Ф50мм дугуй дискэн шүүлтүүр 120 тортой	
12	Троник	ш	2	Ф40x50x40мм троник PE	
13	Троник	ш	3	Ф32x40x32мм троник PE	
14	Троник	ш	3	Ф32x32мм троник PE	
15	Булан	ш	3	Ф40мм булан PE	

16	Булан	ш	4	Ф32мм булан PE	 
17	Шилжүүлэг	ш	1	Ф50x40мм шилжүүлэг PE	
18	Шилжүүлэг	ш	2	Ф40x32мм шилжүүлэг PE	
19	Шилжүүлэг	ш	5	Ф32x25мм шилжүүлэг PE	
20	Шилжүүлэг	ш	5	Ф25x16мм шилжүүлэг PE	
21	Салаалан холбогч	ш	55	Ф32мм салаалан холбогч PE	
22	Салаалан холбогч	ш	55	Ф25мм салаалан холбогч PE	
23	Салаалан холбогч	ш	90	Ф16мм салаалан холбогч PE	

**Тайлбар:**

Дээрх зүлэг усалгааны систем бороожуулах хошуу нь зочдын тавцангийн ногоон байгууламжийн усалгаа арчлах хийх нийт 3200м<sup>2</sup> талбайг услахад шаардлагатай усалгааны систем, бороожуулах хошуу болно.

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Сантехникийн сэлбэг хэрэгсэл	Тавигдах шаардлага болон техникийн тодорхойлолтын /Хавсралт-1/ дагуу			“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ны төв агуулах дээр бууна.	Гэрээ байгуулагдаж, захиалга өгсөнөөс хойш 14 хоног	Захиалагч хойш 30 хоног	
Зүлэг усалгааны систем, бороожуулагч хошуу	Тавигдах шаардлага болон техникийн тодорхойлолтын /Хавсралт-2/ дагуу						

Тав. **ЖИШИГ МАЯГТ**  
**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших  
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт  
2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх  
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх  
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа  
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа **[моо]** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах  
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр  
7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан тоо]** ажлын хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь  
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах  
9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах  
10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх  
11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлд заасны дагуу барааг хүлээн авах үед Захиалагч талыг төлөөлж захиалагчийн сонгосон эрх бүхий этгээд барааг шалгаж хүлээн авна. Барааг шалгахтай холбоотой бүхий л зардлыг Гүйцэтгэгч тал хариуцна.
1. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1 Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
2. Төлбөр (ГЕН-7)
- 1.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээнд заасан барааг **100** хувь нийлүүлсэн болохыг нотолсон барааг хүлээн авсан акт, нэхэмжлэх болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн ажлын 14 хоногийн дотор нийлүүлэгч талд бүрэн төлнө.
4. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>
- 1.1 Алданги ноогдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн **[0.5%]** байна
- Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн **[10 хувь]** байна.

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

БАТЛАВ.

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.



Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

#### **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

---

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.